МЭДЭЭ · 2022 оны 6-р сарын 10

СЭЖИГТНИЙГ БАРИВЧЛАХ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХИЙГ ЗӨРЧИХГҮЙ БАЙХ ТАЛААР СУРГАЛТ ХИЙЛЭЭ



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдөр сэжигтнийг баривчлах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллах, хүний эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарласан аливаа тохиолдол гаргахгүй байхад анхаарч тус дүүрэг дэх Цагдаагийн газрын III хэлтсийн мөрдөгч нарт сургалт хийлээ.

Сургалтыг "Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаанд хүний эрхийг зөрчихгүй байх, анхаарах асуудал" сэдвээр зохион байгуулсан байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2226